

ЭРҮҮЛ МЭНД, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны 5 дугаар сарын 1

Дугаар 147/У/15

Улаанбаатар хот

Зоонозын халдварт өвчний үед хүн, мал эмнэлгийн  
байгууллагууд хамтран ажиллах журам батлах тухай

Монгол Улсын УИХ-ын 2010 оны 23 тоот тогтоолоор батлагдсан “Монгол мал” Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолоор батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх чиглэлийн өвчний жагсаалтыг нэгдүгээр, Зоонозын халдварт өвчний үед хүн, мал эмнэлгийн байгууллагууд хамтран ажиллах журмыг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Уг журмыг хэрэгжүүлэн, зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх чиглэлийн өвчнүүдтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газар (П.Дамдиндорж) Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Отгонбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Б.Бурмаа) нарт даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Н.ХҮРЭЛБААТАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД  
Г.БАДАМЖУНАЙ

16

Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2012 оны 5 дугаар сарын 1 өдрийн 147/А.175 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх чиглэлийн өвчний жагсаалт

Нэг. Хамтарсан тандалт хийх зоонозын халдварын тэргүүлэх өвчнүүд:

1. Тарваган тахал
2. Шувууны томуу
3. Боом
4. Бруцеллёз
5. Галзуу
6. Хачигт энцефалит
7. Бэтэг
8. Хулгана тахал

Хоёр. Хамтарсан судалгаа хийх зоонозын халдварын тэргүүлэх өвчнүүд:

1. Хумхаа
2. Денге халуурал
3. Ям
4. Токсоплазмоз
5. Баруун Нилийн халуурал
6. Япон энцефалит
7. Бөөрний цусархаг хам шинжит халуурал
8. Криптоспоридиоз
9. Ку халуурал

161  
Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн сайдын 2012 оны 5 дугаар  
сарын 1 өдрийн 147/А/13 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт

Зоонозын халдварт өвчний үед хүн, мал эмнэлгийн  
байгууллагууд хамтран ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

ДЭМБ-ын Ази, Номхон Далайн Бүс (WPRO, SEARO), НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (FAO), Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас (OIE) гаргасан “Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал, ДЭМБ-ын “Үндэсний түвшинд хүн, мал эмнэлгийн салбар хоорондын хамтын ажиллагааг бий болгох удирдамж”-ийг үндэслэн энэхүү журмыг боловсруулсан.

Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хэмжээнд байгалийн голомтот зоонозын халдварт өвчний үед хүн, мал эмнэлгийн байгууллагын хамтын ажиллагаа, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамтын ажиллагааны үндсэн чиглэл

Хүн, мал эмнэлгийн байгууллага нь дараах чиглэлийн дагуу хамтран ажиллана.

Үүнд:

- Мэдээ, мэдээлэл солилцох;
- Тандалт, судалгаа хийх;
- Хариу арга хэмжээ авах;
- Эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулах.

2.1. Мэдээ, мэдээлэл солилцох:

2.1.1. Зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх өвчний жагсаалтад багтсан хүний өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг аймгийн Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв (БГХӨСТ)-өөс Байгалийн голомтот

161

халдварт өвчин судлалын үндэсний төв (БГХӨСҮТ)-ийн 632853 тоот утас болон [zoonosis\\_tandalt@yahoo.com](mailto:zoonosis_tandalt@yahoo.com) цахим хаягаар 2-4 цагийн дотор ирүүлнэ.

2.1.2. Зоонозын халдварын малын өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газраас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газар (ЗГХА-МЭҮГ)-т 24 цагийн дотор мэдээлнэ.

2.1.3. Тарваган тахал өвчний агуулагч амьтдын үхэл хорогдол, багц өвчлөлийн тухай мэдээг аймгийн Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төвөөс БГХӨСҮТ-д 24 цагийн дотор мэдээлнэ.

2.1.4. Шувууны өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газраас ЗГХА-МЭҮГ-т мэдээлнэ.

2.1.5. Орон нутгийн түвшингийн Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрууд нь тайван үеийн мэдээг 14 хоног тутам тогтмол солилцоно.

2.1.6. БГХӨСҮТ, ЗГХА-МЭҮГ-ын мэдээллийн ажилтнууд хамтран 14 хоног тутмын эргэн мэдээлэл бэлтгэн цахим хэлбэрээр түгээнэ.

2.1.7. Хүн, мал эмнэлгийн байгууллагуудын захирал нь мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтанг томилон, ажил, үүргийн хуваарийг тодорхой болгон үүрэгжүүлнэ.

## 2.2. Тандалт, судалгаа хийх:

2.2.1. Зоонозын халдварт өвчний идэвхтэй тандалт, судалгааг Зоонозын салбар дундын зөвлөлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

2.2.2. Зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх чиглэлийн 3-5 өвчний илрүүлэлтэд чиглэсэн судалгааг жилд 1-2 удаа тогтмол гүйцэтгэнэ.

2.2.3. Тандалт, судалгааны багийн бүрэлдэхүүн болон хэрэгжүүлэх үйл ажиллагааг БГХӨСҮТ, ЗГХА-МЭҮГ-ын даргын хамтарсан удирдамжаар батлана.

2.2.4. Тандалт, судалгааны үр дүн, зөвлөмжид үндэслэн холбогдох эрхзүйн орчныг БГХӨСҮТ, ЗГХА-МЭҮГ- жил тутам шинэчлэнэ.

2.2.5.БГХӨСҮТ нь хамтарсан тандалт, судалгааны үр дүнг хэлэлцүүлэх уулзалт, ярилцлагыг жил бүр зохион байгуулна.

2.2.6.БГХӨСҮТ, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ)-ийн мэргэжилтнүүд хүн, малын боом өвчний голомтын газар зүйн мэдээллийг Arcview GIS программыг ашиглан бүртгэлжүүлнэ.

2.2.7.Хамтарсан тандалт, судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичиж нийтлүүлнэ.

2.2.8.Хамтарсан тандалт, судалгаанд зарцуулах зардлыг тухайн байгууллага төсөвтөө тусган шийдвэрлүүлнэ.

2.3. Хариу арга хэмжээ авах:

2.3.1. Зоонозын халдварт өвчний голомтод ажиллах хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнийг БГХӨСҮТ, ЗГХА-МЭҮГ-ын дарга нар томилно.

2.3.2. Зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх өвчний хүний өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед багийг тархвар судлагч их эмч ахлаж, бүрэлдэхүүнд лабораторийн эмч, малын эмч, лаборант, ариутгагч, жолооч нар ажиллана.

2.3.3. Зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх өвчний малын өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед голомтод ажиллах багийг мал эмнэлгийн байгууллагаас томилогдсон ажилтан ахлаж, бүрэлдэхүүнд тархвар судлагч их эмч, лабораторийн эмч, лаборант, ариутгагч, жолооч нар ажиллана.

2.3.4. Шаардлагатай тохиолдолд биологч, халдвартын эмч, эрсдлийн үеийн харилцаа холбоо хариуцсан ажилтан, Талбарын тархвар судлал сургалтын хөтөлбөрийн оюутан, олон улсын байгууллага, онцгой байдал, мэргэжлийн хяналт, байгаль, орчны асуудал хариуцсан байгууллагын мэргэжилтнүүдийг ажиллуулна.

2.3.5. Хамтарсан хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнийг жил бүр сургалт, дадлагажуулах сургалтад хамруулна.

2.3.6. Голомтод тухайн зоонозын халдварт өвчний талаарх заавар, журмыг мөрдөн ажиллана.

2.3.7. Хамтарсан хариу арга хэмжээний багийн ахлагч нь удирдах дээд шатны байгууллагад 4 цаг тутам голомтын төлөв байдлын талаар мэдээ өгнө.

2.3.8. Хамтарсан баг нь тархвар судалгааны асуумж авч, бичиглэл, судалгаа хийн, таамаглал дэвшүүлж, тархвар судлалын аналитик судалгаа хийнэ.

2.3.9. Голомтын хүрээний хүн амд эмнэлзүйн үзлэг хийж, эрсдэлт хүн амыг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулна.

2.3.10. Зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх, халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулна.

2.3.11. БГХӨСҮТ, УМЭАЦТЛ-ийн мэргэжилтнүүд лабораторийн шинжилгээний явц, үр дүнг харилцан мэдээлж ажиллах ба шаардлагатай тохиолдолд Олон Улсын лавлагаа лабораториор баталгаажуулна.

2.3.12. Голомтод хамтарсан хариу арга хэмжээ авсан тухай илтгэх хуудас, тайланг бичиж, салбар дундын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

2.3.13. Хамтарсан хариу арга хэмжээний багийн зардлыг тухайн байгууллага төсөвтөө тусган шийдвэрлэнэ.

#### 2.4. Эрсдлийг бууруулах ажил зохион байгуулах:

2.4.1. Эрсдлийн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг БГХӨСҮТ, ЗГХА-МЭҮГ-ын даргын хамтарсан тушаалаар томилно.

2.4.2. Жил бүр зоонозын халдварын тандалт, судалгааны тэргүүлэх 2-3 өвчний эрсдлийн үнэлгээг хамтран хийж, зөвлөмж боловсруулна.

2.4.3. Эрсдлийн үнэлгээний зөвлөмжид үндэслэн БГХӨСҮТ, аймаг, орон нутаг дахь Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төвийн төлөвлөгөөнд тусган голомт эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, 14 хоногийн дотор гүйцэтгэлийн талаар тайланг ирүүлнэ.

2.4.4. Зоонозын халдварт өвчин гарахаас сэргийлж, урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг хүн, мал эмнэлгийн байгууллагын хамтарсан баг тогтмол гүйцэтгэнэ.

2.4.5. БГХӨСҮТ-өөс эрсдэлт бүс нутгийн хүн амын дархлаажуулалтад хамрагдагсдын судалгааг шинэчлэн гаргаж, зоонозын халдварт өвчний дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ.

2.4.6. Зоонозын халдварт өртөх эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг хүн, мал эмнэлгийн мэргэжилтнүүд тогтмол зохион байгуулна.

2.4.7. Эрсдлийн үнэлгээ хийсэн багийн бүрэлдэхүүн нь үнэлгээний дүн, зөвлөмжийг шийдвэр гаргагч танилцуулах уулзалт, ярилцлагыг жилд 2 удаа зохион байгуулна.

2.4.8. Эрсдлийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор БГХӨСҮТ, ЗГХА-МЭҮГ-ын даргын хамтарсан удирдамжаар бодлогын баримт бичгийг шинэчлэх, шинээр боловсруулах ажлын хэсгийг томилон ажиллуулна.

2.4.9. Хамтарсан багт шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж, лабораторийн багаж хэрэгсэлийн нөөцийг тухайн байгууллага төсөвтөө тусган бэлэн байдлыг ханган ажиллана.